



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ



**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ
ТАСЛАН ЗОГСООХ, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ**

ЯМАР ТОХИОЛДОЛД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ НУУЖ ТЭВЧСЭЭР БАЙДАГ ВЭ?

- 1 Засарна гэж найдсаар байдаг
- 2 Амлалтад нь итгэдэг
- 3 Хүчирхийллийн битүү тойргийн уучлалт гуйх, гэмших үед эвлэрдэг
- 4 Үр хүүхдээ элэг бүтэн өсгөхийг хүсдэг
- 5 Тэсэж тэвчих хувь тавилан гэж ойлгодог
- 6 Өөрийгөө буруутгадаг
- 7 Өөртөө итгэлгүй, салалтаас эмээдэг
- 8 Өөрийн гэсэн орлого бага, эдийн засгийн хувьд хамрааралтай байдаг
- 9 Алслагдсан газар амьдардаг
- 10 Бага насны хүүхэдтэй
- 11 Хөгжлийн бэрхшээлтэй
- 12 Нэр төрөө бодох, уламжлалт ёс заншил, итгэл үнэмшилдээ баригдах

ЯМАР ТОХИОЛДОЛД МЭДЭЭЛЭГДДЭГ ВЭ?

- ✓ Архидан согтуурч, агсам тавьж, амь нас, эрүүл мэндэд халтай үйлдэл хийх үед
- ✓ Амь насанд эрсдэлтэй, ноцтой бэртэл гэмтэл авсан үед
- ✓ Үр хүүхдийн хүмүүжил, хөгжил, сэтгэл санаанд сөрөг нөлөөлөл үзүүлж буйг ухаарах үед
- ✓ Засарна гэсэн итгэл алдарсан үе

ӨӨРТӨӨ БА БУСАД ТУСАЛЖ ЧАДНА




Санамж: Дарамт, хүчирхийлэлтэй харилцаанаас чөлөөлөгд. Та хүчирхийлэл, дарамтаас ангижрахыг хүсэвч хүчирхийлэгчээс айж эмээсээр байна уу? Амьдрал хүнд хэцүү, гарах гарцгүй мэт байгаа ч өөрийгөө хамгаалах алхмуудыг хэрэгжүүлж болох юм. Та ганцаараа биш, тусламж дэмжлэг болох гарцууд байгаа гэдэгт итгээрэй.

ТАНЫ ХИЙЖ ЧАДАХ АЛХАМУУД:

- » Өөрийгөө бүү буруутга,
- » Та хүчирхийлэл, дарамтад байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх
- » Хүчирхийллийн ямар хэлбэрүүд таны амьдралд хэрхэн давтагдаж, даамжирч байгааг дүгнэх,
- » Нөхцөл байдал цаашид энэ хэвээр үргэлжилбэл ямар хор хохиролд хүргэж болохыг дүгнэх,
- » Асуудлыг хэрхэн шийдэх хүсэлтэй байгаагаа тодорхой болгох,
- » Хүчирхийлэл, дарамтыг эцэс болгоход таны шийдвэр туйлын чухал гэдгийг ойлго,
- » Өөртөө итгэ: Хүчирхийлэл, дарамтанд цэг тавьж чадна гэдэгтээ итгэх,
- » Хамаатан садан, найз нөхөд болон танд туслах бусад хүмүүстэй харилцдаг байсан сайн холбоогоо сэргээх,
- » Танд хамгийн ойрхон дэмжлэг үзүүлж болох нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, нэг цэгийн үйлчилгээ, цагдаагийн газар зэргийг мэдэж ав, тэдэнд хандах,
- » Сэтгэл санааны болон бусад хэрэгцээт дэмжлэг үзүүлж чадах мэргэжлийн хүмүүс, нийгмийн ажилтан зэрэгт хандах,
- » Өөрийн болон үр хүүхдийнхээ аюулгүй байдлыг хангах тактик, төлөвлөгөөг боловсруулах,
- » Өөртөө тавих анхаарлаа бүү сулруул. Өөдрөг, тууштай, ухаалаг, эрч хүчтэй байхад тань туслах зөв зүйтэй арга хэрэгслүүдээс суралцаж ашиглах,
- » Үр хүүхдэдээ цаг гарган хамт байж нээлттэй ярилц, тэднийг байнга сонсох
- » Түүнд санаа тавьж анхааралтай сонс бас нээлттэй харилцах
- » Гайхаж, цочирдсон байдал үзүүлэхээс зайлсхийх
- » Болж буй хүчирхийлэлд хохирогчийг бүү буруутга
- » “Анхнаасаа яах гэж түүнтэй суусан юм бэ?, Мэдсээр байж юу гэж өдийг хүртэл дуугүй явсан юм?, Эргүүлээд болгоод өгөхгүй яасан юм” гэх зэргээр хохирогчийг янз бүрээр буруутгахаа урьтал болгодог нь маш буруу үйлдэл юм. Ийм хариу үйлдэл нь хохирогчид ямар ч дэмжлэг болохгүйн дээр түүнд төрөл бүрийн байдлаар хор хөнөөлтэй тусч болно. Тухайлбал, хохирогч өөрийгөө хүчирхийллийн буруутан гэж итгэх, өөрийгөө хүчтэй, зоригтой алхам хийж чадахгүй гэж үзэхэд хүргэдэг.

ХЭРЭВ ТА ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД САНАА ЗОВИНОЖ БАЙГАА БОЛ ДАРААХ ЗҮЙЛИЙГ АСУУЖ, САНУУЛААРАЙ



ТАНЫ ХИЙЖ БОЛОХГҮЙ ЗҮЙЛС



- ✔ Би таны болон хүүхдүүдийн тань аюулгүй байдалд санаа зовж байна” гэж хэлээрэй, энэ талаарх түүний санал, бодлыг сонсоорой,
- ✔ “Та нөхрөөсөө эсвэл эхнэрээсээ айж байна уу?” гэж асуугаарай., ямар аюул занал, эрсдэл байгааг тодруулаарай.
- ✔ Хүчирхийлэгчийн харилцаа, хандлага аяндаа засарч хэвийн болно гэж найдаж болохгүй мөн чимээгүй байх тусам хүчирхийлэл даамжирдгийг сануулаарай.
- ✔ Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг ажилладаг мэргэжлийн байгууллагууд түүний гаргасан шийдвэрийг хүндэтгэн, үндэслэл болгон хэрэгцээт дэмжлэг, тусламжийг үзүүлдэг болохыг хэлээд түүний гаргах шийдвэр өөрт нь хамгийн чухал болохыг хэлээрэй.

- ⚠ Хохирогч танаас тусламж хүсч ирэхийг хүлээх,
- ⚠ Түүнийг шүүж эсвэл буруутгах
- ⚠ Түүний нөхцөл байдалд цочирдсон, гайхсан, эргэлзсэн, үл итгэсэн мэдрэмж төрүүлэх үг, үйлдэл хийх,
- ⚠ Түүний сэтгэл санаа, аюулгүй байдал, эдийн засагт дарамт болох ямар нэг зүйл хийх, хэлэх,
- ⚠ Тусламж дэмжлэг үзүүлэхдээ ямар нэг болзол, нөхцөл байдал шаардах,
- ⚠ Түүнд бодитой дэмжлэг, тусламж болох алхамууд л хэрэгтэй, харин ямар ч дэмжлэг болохгүй зөвлөмж, олон үг яриа, бусдын хүчирхийлсэн түүх, харьцуулалт чухал биш,
- ⚠ Ямар ч хариу хэлэхгүй огт дуугүй байх (дуугүй байх нь түүнийг үл ойшоосон эсвэл түүнийг буруутай гэж үзэж буй мэт мэдрэмжийг өгдөг тул танд ямар мэдрэмж төрж буйг хуваалцаж байх)

ХААНА ХАНДАХ ВЭ?



НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг нэг дор үзүүлэх ажиллагааг хэлнэ.



ТҮР ХАМГААЛАХ БАЙР:

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг тодорхой хугацаагаар байрлуулан аюулгүй байдлын хамгаалалт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, холбон зуучлах үйлчилгээг үзүүлэх зориулалт бүхий стандарт хангасан газрыг хэлнэ.



ХОЛБОН ЗУУЧЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ:

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ.

ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ДАРУЙ АВАХ ҮҮРЭГТЭЙ.

Хүний амь насыг аварч байгаа тул мэдээлэл өгсний төлөө Танд хариуцлага хүлээлгэхгүй.

Мэдээлэл өгснийг тань нууцална. Нууцлалыг задруулсан хүнд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Таныг ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН дагуу хамгаална.

УТСААР МЭДЭЭЛЭЛ ӨГЧ, ЗӨВЛӨГӨӨ АВЧ БОЛНО.



107

Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага хүлээн авах, зөвлөгөө, мэдээлэл өгөх утас



102

Цагдаагийн мэдээлэл, шуурхай удирдлагын төв



108

Хүүхдийн тусламжийн утас

БАЙНГА...24 ЦАГААР АЖИЛЛАНА /нэгж шаардахгүй/



ШИНЭ ДЭД ТӨВ

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Бага тойруу 1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө, Г-корпус-415

Утас: (976)-70003099

Факс: (976)-70003098

И-мэйл: info@ub-subcenter.mn

Веб: www.ub-subcenter.mn